



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/401

Булган сум

Сумдын баяр наадмын хугацааг
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тулгар төрийн 2232 жил, Их Монгол улсын 817 жил, Үндэсний их баяр наадам-Ардын хувьсгалын 102 жил, Ардчилсан хувьсгалын 34 жилийн ойн Булган аймгийн сумдын баяр наадмыг 2023 оны 07 дугаар сарын 1-2-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө гарган, Үндэсний их баяр наадам угтсан тохижилт, бүтээн байгуулалт, соёлжилтыг дээшлүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулж, нийтийн хэв журмыг сахиулах, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрүүл мэнд, цагдаагийн болон бусад албан хаагчдыг ажиллуулахыг сумын Засаг дарга, албан байгууллага, аж ахуй нэгжийн дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ